



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/84

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн “Сумын 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай”.04 дүгээр тогтоол, сумын Онцгой комиссын 2023 оны 04 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1.Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 2 дугаар багийн “Цагаан толгой” гэх газарт, малчны хотноос малын гоц халдварт мялзан өвчний шинж тэмдэг илэрсэн нь тогтоогдож, суманд хязгаарлалтын дэглэм тогтоон хяналтын пост ажилллуулж байгаатай холбогдуулан гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, хамгаалан ажиллах арга хэмжээний хүрээнд 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Гамшгаас хамгаалах арга хэмжээний зардал”-аас 5,000,000 (таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Арга хэмжээнд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3.Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулж, үнэн зөв тайлагнахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш), Онцгой комиссын Нарийн бичгийн дарга (Л.Алдар) нарт зөвшөөрсүгэй.

4.Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА П.ГАНЧИМЭГ



Сумын Засаг даргын 2023 оны 05-р
сарын 29-ны өдрийн 1184 дугаар
захирамжийн хавсралт

Сумын постын хүнс, ахуйн хэрэглээ, шатахуун, томилолтын төсөв

д/д	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Тайлбар
1	Будаа / 5кг/	ш	2	32500	65000	
2	Гоймон / 3кг/	ш	2	8500	17000	
3	Цайны идээ	ш	2	7300	14600	
4	Давс	ш	3	2500	7500	
5	Хуурай сүү	ш	3	15000	45000	
6	Хонины мах	кг	70	12000	840000	
7	Боорцог	кг	10	12000	120000	
9	Ургамлын тос	ш	5	12500	62500	
10	Сонгино	кг	4.8	3500	16800	
11	Сормис	ш	3	4500	13500	
12	Хүнсний ногоо	кг	15	5000	75000	
13	Гурил	кг	20	2500	50000	
Хүнсний дүн					1326900	
Ахуйн хэрэглээ						
1	00-ын цаас	ш	5	1500	7500	
2	Сальфетак нойтон	ш	3	7500	22500	
3	Саван	ш	3	1800	5400	
4	Угаадаг алчуур	ш	1	12000	12000	
5	Аяга таваг угаагч	ш	1	8000	8000	
6	Гар ариутгагч санитол	ш	2	6500	13000	
7	Нүүрс	ш	5	7500	37500	
8	Хогийн уут	ш	2	8500	17000	
Ахуйн хэрэглээний дүн					122900	
Шатахуун						
1	Шатахуун			3000000	3000000	
Шатахууны дүн					3000000	
Тогоочийн цалин						
д/д	Бараа материалын нэр	хэмжих нэгж /хүн/	Тоо	Нэг өдрийн зардал	Нийт зардал	Тайлбар
1	Ажлын хөлс	1	21	26200	550200	
Ажлын хөлс дүн					550200	
Зардлын нийт дүн					5000000	